



**ОюуТолгой ХХК**

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин,  
Аюулгүй байдал, Орон нутаг

Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын  
төлөвлөгөө

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 3.0

**АГУУЛГА**

<b>3</b>	<b><u>Танилцуулга</u></b> .....	<b>4</b>
1.1	<u>Баримт бичгийн дугаар</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
1.2	<u>Зорилго</u> .....	4
1.3	<u>Хэрэглээ</u> .....	4
1.4	<u>Хэрэгжүүлж эхлэх хугацаа</u> .....	4
1.5	<u>Эрх мэдэл болон удирдлага</u> .....	4
<b>4</b>	<b><u>Хамрах хүрээ</u></b> .....	<b>5</b>
2.1	<u>Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ</u> .....	5
2.2	<u>Удирдлагын бусад төлөвлөгөөтэй давхцах байдал</u> .....	5
<b>5</b>	<b><u>Үүрэг хариуцлага</u></b> .....	<b>5</b>
3.1	<u>Удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн гол үүрэг , хариуцлагууд</u> .....	5
3.2	<u>Гол үялдаа холбоо</u> .....	8
<b>6</b>	<b><u>Төслийн стандартууд</u></b> .....	<b>6</b>
4.1	<u>Холбогдох Монгол улсын үндэсний стандартууд</u> .....	9
4.2	<u>БОНБНУ-ны шаардлагууд</u> .....	10
4.3	<u>Монгол улсын ЗГ болон холбогдох төрийн байгууллагуудын өмнө хүлээсэн үүрэг ба тавигдаж буй шаардлагууд</u> .....	7
4.4	<u>Зээлдүүлэгчдийн стандарт болон удирдамжууд</u> .....	11
4.5	<u>Рио Тинтогийн стандартууд</u> .....	11
4.6	<u>Оюутолгойн дагаж мөрдөх үүрэг бүхий бусад аж үйлдвэрийн салбарын зааварчилгаанууд</u> 11	
4.7	<u>Төсөлд хэрэглэх стандартуудын хураангуй</u> .....	12
<b>7</b>	<b><u>Нөлөөлөл бууруулах арга хэмжээ, удирдлагын хяналтууд</u></b> .....	<b>9</b>
<b>8</b>	<b><u>Хэрэгжилтийн хуваарь</u></b> .....	<b>14</b>
6.1	<u>Удирдлагын төлөвлөгөөний хяналт болон өөрчлөлт</u> .....	14
6.2	<u>Хэрэгжилтийн гол үе шатууд</u> .....	14
<b>9</b>	<b><u>Мониторинг</u></b> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
7.1	<u>Мониторингийн шаардлагын тойм</u> .....	14
7.2	<u>Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
7.3	<u>Мониторингийн гол үйл ажиллагаанууд</u> .....	15
<b>10</b>	<b><u>Сургалт</u></b> .....	<b>16</b>
8.1	<u>Тойм</u> .....	23

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 3.0

8.2 <a href="#">Чиг баримжаа олгох сургалт, зааварчилга</a> .....	23
8.3 <a href="#">Сургалтанд тавигдах бусад шаардлагууд</a> .....	23
<b>11 <a href="#">Аудит болон тайлагналт</a>.....</b>	<b>24</b>
9.1 <a href="#">Дотоод аудит</a> .....	24
9.2 <a href="#">Гадаадаудит</a> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
9.3 Баримт хадгалалт.....	24
<b>12 <a href="#">Баримт бичгийн мэдээлэл</a>.....</b>	<b>24</b>
<b>Хүснэгтүүд</b>	
Хүснэгт 1: Гол үүрэг, хариуцлага хүлээх хүмүүс.....	5
<a href="#">Хүснэгт 2: Удирдлагын гол хяналтууд</a> .....	11
Хүснэгт 3: Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд.....	14
Хүснэгт 4: Мониторингийн хэмжилтүүд - Химийн аюултай бодисын удирдлага .....	15

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 3.0

## 1. ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Зорилго

Удирдлагын төлөвлөгөөний зорилго нь:

- удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, удирдлагын холбогдох нэгжүүдийн уялдаа холбоог харуулах;
- ажлын байрны үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
- энэ удирдлагын төлөвлөгөөнд хамаарах төслийн холбогдох стандартуудыг тоймлон гаргах;
- энэ удирдлагын төлөвлөгөөтэй хамааралтай төслийн үүрэг хариуцлага, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, үйл ажиллагааны журам болон зааварчилгааг тодорхойлох;
- гүйцэтгэлийн гол үзүүлэлтийг багтаасан мониторингийн болон тайлагналтын журмыг тодорхойлох;
- сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ба
- дагалдах материал, мэдээллийн иш татсан баримт бичгүүдийг бүрдүүлэх зэрэг болно.

### 1.2 Хэрэглээ

Энэ удирдлагын төлөвлөгөөнд заасан шаардлагууд нь Оюутолгой компанийн болон гэрээт компаниудын бүхий үйл ажиллагаанд хамааралтай болно.

Тус удирдлагын төлөвлөгөөг Рио Тинтогийн *Байгаль орчны стандарт E15 Аюултай материал болон эрдсийн бус хог хаягдлын хяналт, тэдгээрийг бууруулах стандарт* дээр үндэслэн боловсруулсан болно. Рио Тинтогийн *E15 Аюултай материал болон эрдсийн бус хог хаягдлын хяналт, тэдгээрийг бууруулах стандарта* өөрчлөлт орвол Оюу толгойн удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт орно.

### 1.3 Хэрэгжүүлж эхлэх хугацаа

Энэ удирдлагын төлөвлөгөө нь 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болно.

### 1.4 Эрх мэдэл болон удирдлага

Оюутолгойн гүйцэтгэх хороо нь энэхүү удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр баталсан ба тухайн баримт бичгийг хамгийн багадаа гурван жил тутамд хянагдаж байна.

Оюутолгойн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутгийн асуудал хариуцсан ерөнхий менежер нь тус удирдлагын төлөвлөгөөг хариуцна. Төслийн бүтэц, дүрэм журамд орсон өөрчлөлтийг тусгахаар илүү ойр ойрхон давтамжтайгаар хянан шинэчлэх шаардлагатай болоогүй л бол тус Удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутам хянаж, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт, шинээр мэдээлэл оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлно. Удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах аливаа саналыг энэхүү албан тушаалтанд хандан гаргах ба тэрээр Өөрчлөлтийг удирдах дүрэм журамд заасны дагуу хянаж батална.

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 3.0

## 2 ХАМРАХ ХҮРЭЭ

### 2.1 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөөг Оюутолгойнбүхий л үйл ажиллагаанд, тэр дундаа гэрээт ажилтнуудын үйл ажиллагаанд, асгаралт ба байгаль орчин бохирдуулахаас урьдчилан сэргийлэх үүднээс аюултай материалыг удирдлгн зохицуулахад, түүнчлэн , материалыг аюулгүй хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанд хамаарна.Энд тусгасан хяналтын арга хэмжээнүүд нь байгаль орчинд учруулах эрсдлийг хамруулахын зэрэгцээ аюултай бодисын асгаралт болон бусад хүчин зүйлээс үүдэлтэй байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахыг баталгаажуулж өгдөг.

Тус төлөвлөгөөг гэрээт гүйцэтгэгчид хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг гэрээт гүйцэтгэгчдийнудирдлагынбичиг баримтандтусгасан болно.(лав: ОТ-07-PLN-0001).

#### ***Аюултай материал/бодисын тодорхойлолт (Рио Тинтогийн ЭМААБООН-ийн мэдээллийн сангаас авсан тодорхойлолт)***

Үүнд хүний эрүүл мэнд ба/буюу байгаль орчинд дунд, урт хугацаанд аюул учруулах, ажлын байран дээр хэрэглэж буй бодис, материал орно. Эдгээр бодисоор амьсгалах, залгих, арьсаараа хүрэлцсэн үед хүмүүст хор хөнөөл учруулна. Үр нөлөө нь хурцаас архаг хэлбэртэй байж хүмүүст цочроох, хордлогын, харшлын, хортой шинжээр илэрнэ. Байгаль орчинд шингэх, био хуримтлал үүсгэх ба/буюу бүрхүүл бий болгосноос байгаль орчинд хорт нөлөөлөл үзүүлнэ. Аюултай бараа бүтээгдэхүүнийг мөн үзнэ үү.

#### ***Эрдсийн бус хог хаягдлын тодорхойлолт (Рио Тинтогийн ЭМААБООН-ийн мэдээллийн сангаас авсан тодорхойлолт)***

Уул уурхай, боловсруулалт болон тэдгээртэй холбогдох үйл ажиллагаа(тухайлбал, олборлох, тээрэмдэх, хайлуулах, боловсруулах үйл ажиллагаа)-нд ашиглах хэрэглээний зүйлсээс гарах хог хаягдал, тэр дундаа аж үйлдвэрийн болон засварын цехийн хаягдал, ашигласан галд тэсвэртэй материал, ашигласан тасалгааны доторлогоо, оффисын хаягдал, түргэн муудах хаягдал (хоолны газрын хаягдал), кэмпийн хаягдал, ашигласан тос, тосолгооны материал, дугуй, хаягдал төмөр, барилгын хаягдал, био эмнэлгийн хаягдал, уурхайн цогцолбороос гарах хог хаягдал орно. Эрдсийн бус хог хаягдалд уурхайн чулуулаг болон сул тунамал чулуулгийг олборлох, боловсруулах үйл ажиллагаанаас шууд гарсан хог үлдэгдлийг оруулахгүй болно.

### 2.2 Хог хаягдлын удирдлагын ерөнхий аргачлал

Энэ удирдлагын төлөвлөгөөний зорилт бол хог хаягдал үүсэхийг хамгийн бага хэмжээнд байлгах, үүссэн хог хаягдалтай аюулгүй харьцах, боловсруулах, зайлуулах замаар Оюу Толгойн эрдсийн бус хог хаягдлын үр дүнтэй удирдлагыг хэрэгжүүлэх явдал юм. Энэ зорилтонд Хог хаягдлын шаталсан удирдлагыг хэрэгжүүлэх замаар хүрнэ. Үүнд:

- хог хаягдлын эх үүсвэрийг хамгийн бага хэмжээнд байлгаж, хог хаягдал үүсэхээс зайлсхийх;
- хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах;
- хог хаягдлыг дахин ашиглаж; улмаар
- олон улсын стандартын дагуу хог хаягдлыг хадгалж, боловсруулан хаях.

Үйл ажиллагаанд хэрэглэгдэх боломжтой, хамгийн бага материал бүхий савлагаатай бүтээгдэхүүн нийлүүлэх ханган нийлүүлэгчийг сонгох болон бараа бүтээгдэхүүнийг хугацааг нь дуусахаас нь

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 3.0

өмнө ашиглаж, хэрэглэхийг хянадаг нарийн удирдлагийг хэрэгжүүлэх замаар хог хаягдлыг бууруулах болон үүсэхээс зайлсхийнэ.

Орон нутагтай хамтран ажиллах болон үнэлэгээ хийлгэж, зохих тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдлыг дахин ашиглагч гэрээт гүйцэтгэгчтэй хамтран ажиллах замаар хог хаягдлыг дахин ашиглах ажлыг хэрэгжүүлнэ.

Зөвшөөрөгдсөн аюулгүй хог хаягдлыг булшлах байгууламж болон аюултай хог хаягдлыг шатаах автоклав бүхий уурхайн талбайн хог хаягдлын удирдлагын төвд хог хаягдлыг боловсруулж, зайлуулна.

### 2.3 Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь Оюутолгой төслийн боловсруулсан Ашиглалтын шатныудирдлагын цогц төлөвлөгөөнүүдийн нэг хэсэг бөгөөд энэ талаар Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНМТ)-ний хүрээнд тусгасан болно. (лав: ОТ-10-PLN-0003).

Тус удирдлагын төлөвлөгөө нь хэд хэдэн удирдлагын төлөвлөгөөнүүдтэй зарим талаар давхцаж, харилцан холбоотой. Үүнд:

- Онцгой байдлын үеийн бэлэн байдал баавах арга хэмжээний төлөвлөгөө (лав: ОТ-12-PLN-0011), ялангуяа аюултай материалын хадгалалттай холбоотойгоор;
- Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө (дугаар: ОТ-10-PLN-0001), ялангуяа аюултай материалаас олон нийтэд үзүүлж болзошгүй нөлөөлөлтэй холбоотойгоор.
- Эрдсийн хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-E13-PLN-0001-E), ялангуяа болзошгүй бохирдлыг хянахтай холбоотойгоор
- Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-E11-PLN-0001-E), ялангуяа болзошгүй бохирдлыг хянахтай холбоотойгоор
- 

## 3 ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

### 12.1 ..... У дирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн голүүрэг, хариуцлага

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцсан албан тушаалтнууд тэдгээрийн үүрэг хариуцлагуудыг доор оймлон харууллаа.

#### Хүснэгт 1: Албан тушаалтан болон тэдгээрийн үүрэг хариуцлага

Албан тушаал	Хариуцлага
<b>ОТ-н Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин, Аюулгүй байдал, Орон нутаг хариуцсан Ерөнхий менежер</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Энэхүү төлөвлөгөөний хамрах хүрээ, хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцах.</li> <li>• Энэхүү төлөвлөгөөнд тусгасан Төслийн стандарт, бусад шаардлагыг Төслийн үйл ажиллагаанд мөрдүүлэх.</li> </ul>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 3.0

<b>Оюутолгойн Байгаль орчин хариуцсан менежер</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Энэхүү удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцах.</li> <li>• Аюултай материал, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө, холбогдох журмын хэрэгжилтийг хангуулахаар ОТ-н хэлтсүүдийн менежер, Гол гэрээт ажилтнуудад техникийн туслалцаа үзүүлэх.</li> <li>• Аюултай материал, эрдсийн бус хог хаягдлын гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй бүхий байгаль орчны улирлын, жилийн тайлан бэлтгэх.</li> <li>• ОТ-н үндсэн болоод гол гэрээт ажилтнуудад энэхүү төлөвлөгөөг хүргүүлэх.</li> <li>• Аюултай материал, эрдсийн бус хог хаягдлын Байгаль орчны хууль, дүрэм журам биелүүлээгүй бүх тохиолдол, осол зөрчлийг мэдээлэх, улмаар засаж залруулах арга хэмжээг авах.</li> <li>• Уурхайн цогцолбор дах Аюултай материал, эрдсийн бус хог хаягдлын төрөл, тоо хэмжээг хянах систем/тогтолцоо бий болгох.</li> <li>• ОТ-н хэлтсүүдийн хооронд үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох үүднээс Аюултай материал, эрдсийн бус хаягдлын хорооны хурлыг</li> </ul>
<b>ОТ-н Ус болон хаягдал хариуцсан Ахлах мэргэжилтэн</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Бүх аюултай хог хаягдал, хаяж зайлуулсан, дахин боловсруулсан хог хаягдлын тоо мэдээг жишиж, дүн шинжилгээ хийх.</li> <li>• Хог хаягдал зайлуулах, хадгалах байдлыг бууруулахаар эрдсийн бус хог хаягдлыг боловсруулах, дахин ашиглах боломж бололцоог нэмэгдүүлэх судалгаа хийх.</li> <li>• Шаардлагатай үед бусад хэлтэс болон төрийн байгууллагуудтай Аюултай материал, эрдсийн бус хог хаягдлын талаар нааштай харилцаа холбоо тогтоох.</li> <li>• ОТ-н хэлтсүүдийн хооронд үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох үүднээс Аюултай материал, эрдсийн бус хаягдлын хорооны хурлыг тогтмол хийж, удирдан зохион байгуулах.</li> <li>• Байгаль орчны жилийн тайлангийн судалгаа, хяналт шинжилгээ, нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны талаарх хэсгүүдийг хянаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яманд ирүүлэх.</li> </ul>
<b>ОТ-н Хог хаягдлын удирдлагын ажилтан</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтцийн багаас Хог хаягдлын удирдлагын төвийн хог хаягдлын статистикийн сарын мэдээллийг авч, холбогдох тайланг гаргах.</li> <li>• Асгаралтын бүртгэл хөтөлж, Асгаралтын үед авах арга хэмжээний журмын дагуу төслийн талбайг цэвэрлэх талаар зөвлөгөө өгөх.</li> <li>• Энэхүү Удирдлагын төлөвлөгөө болон холбогдох Журмын шаардлагын дагуу ОТ-н хэлтсүүд, үндсэн гүйцэтгэгчдийн ажлын байранд байнгын/хугацаат аудит, үзлэг шалгалт хийх.</li> </ul>
<b>ОТ-н дэд бүтцийн хэлтэс</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Аюултай бус хог хаягдлыг булаах, аюултай хог хаягдлыг шатаах автоклав зэрэг Хог хаягдлын удирдлагын төвийн үйл ажиллагааны удирдлагын хяналт тавих.</li> <li>• Энэхүү удирдлагын төлөвлөгөөний дагуу Хог хаягдлын удирдлагын төв дээр хог хаягдал боловсруулах, зайлуулах үйл ажиллагааг явуулах.</li> <li>• Хог хаягдлын удирдлагын төв дээр хаягдалтай харьцах үйл ажиллагааны тоо мэдээг цуглуулах.</li> <li>• ОТ-н инженерчлэлийн багаар ландфилийн урьдчилсан тайланг улирал тутам гаргуулах.</li> <li>• Аюултай, химийн бодисын хаягдлыг Төслийн стандартын дагуу аюулгүй хадгалах.</li> <li>• Хог хаягдлын удирдлагын төв дээр хаягдал боловсруулах Гүйцэтгэгчийн үйл ажиллагааг удирдах.</li> </ul>
<b>Ил болон Далд уурхайн хэлтэс, Үндсэн гүйцэтгэгчийн менежерүүд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Энэхүү удирдлагын төлөвлөгөө, холбогдох журмындагуу холбогдох арга хэмжээг авахад анхаарч ажиллах.</li> <li>• Хэлтсийн ажилтнууд хог хаягдлын менежментийн үйл ажиллагаанд, ялангуяа аюултай хог хаягдалтай ажиллахад бүрэн суралцсан байх.</li> <li>• Осол зөрчлийн судалгааг явуулж, тайлагнах.</li> <li>• Аюултай материалыг зөв зохистой хадгалж, хадгалах байршил дээр Хор Аюулын Лавлах Материал (ХАЛМ) байлгах.</li> <li>• аюултай материал, эрдсийн бус хог хаягдалтай харьцах ажлыг эхлүүлэхээс өмнө энэхүү төлөвлөгөөнд дурдсан шаардлагад нийцүүлэн Гүйцэтгэгчид нь өөрсдийн удирдлагын төлөвлөгөө, хяналт шалгалтын журмыг боловсруулж болно.</li> </ul>
<b>Ажлын байрны Ахлах ажилтан/</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Удирдлагын төлөвлөгөө, холбогдох журмын дагуу холбогдох үйл ажиллагааг явуулуулахаар ажлын талбайд тогтмол хяналт шалгалт хийх.</li> </ul>

Хуудас 7, нийт 26

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ  
ХУУДАСНААС ХАРНА УУ  
ХЭВЛЭСЭН ОГНОО: 2019-06-10

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 3.0

<b>ЭМААБОАБОН хариуцсан баг</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Бүх аюултай материал, хог хаягдлын талаарх мэдээллийг зохих ёсоор бүртгэж тайлах .</li> <li>• Бүх аюул осол, хууль журам биелүүлээгүй тохиолдол, осол зөрчлийг мэдээлж байх.</li> <li>• Байгаль орчны болон аюулгүй ажиллагааны осол зөрчилд хүргэж болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх.</li> <li>• Аюултай материал хадгалах байршлуудад англи, монгол хэл дээр хэвлэсэн ХАЛМ-ыг бэлэн байлгах.</li> </ul>
<b>ЭМААБО-ны хэрэгжилт хариуцсан баг</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний/улсын болон төслийн стандартын дагуу хаягдал боловсруулах гүйцэтгэгчдэд хугацаат аудит шалгалт явуулах.</li> <li>• Хог хаягдлын удирдлагын бүх зөвшөөрлийг авсан байх.</li> </ul>
<b>Сургалтын хэлтэс</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Аюултай материалыг хадгалах, ашиглах болон эрдсийн бус хог хаягдлыг ангилах, зайлуулахад тавих шаардлагын талаар сургалтыг холбогдох бүх ажилтнуудад явуулах.</li> </ul>
<b>Хангамжийн хэлтэс</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Нэр хүнд бүхий ханган нийлүүлэгчээс худалдан авалт хийж, худалдан авсан материалуудтай холбоотой ХАЛМ-ийг хүлээн авах.</li> <li>• Нийлүүлэх материал сонгоходоо ОТ төслийн талбай дахь хог хаягдлыг бууруулах, зайлуулах арга хандлагыг чухалчлах.</li> <li>• ОТ-с үлдээх хүсэлт гаргаагүй бол, үлдсэн, илүү гарсан бүтээгдхүүн, хаягдлыг төсөл нь дуусахад хаяж зайлуулах талаар Гүйцэтгэгчдэд мэдэгдэх.</li> </ul>
<b>Нийгмийн хариуцлагын хэлтэс</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Улаан загалмай нийгэмлэгээр дамжуулан орон нутгийн иргэдэд тараасан дахин ашиглагдах хог хаягдлыг зөвшөөрөгдсөн зорилгоор ашиглаж байгаа эсэхийг шалгах.</li> <li>• Тараасан дахин ашиглагдах хог хаягдлын улирлын тайланг бэлтгүүлж, ОТ-н Байгаль орчны хэлтэст ирүүлэх.</li> </ul>

### 12.2 ..... Г ол уялдаа холбоо

Энэхүү удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилт дэхь голлох харилцаа холбоо (жишээ нь тус удирдлагын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийг хариуцсан албан тушаалтан, түүнийгүйцэтгэх үүрэг, хариуцлага) нь:

- Ялангуяа аюултай материалыг зөв хадгалах, харьцах, мөн зохих, үр дүнтэй байдлаар хуримтлуулах, тэр дундаа ажлын байран дахь хог хаягдлыг ангилах Ил уурхай болон Далд уурхайн хэлтсүүд.
- Аюултай материалуудыг худалдан авч уурхайн талбай дээр хүргэх асуудлын хүрээнд Худалдан авалтын хэлтэс.
- Дэд бүтцийн хэлтэс ялангуяа дараахтай холбоотой үйл ажиллагаа явуулна:
  - Хог хаягдлын удирдлагын төв дээр аюултай материалыг шатаах зууханд тохиромжтой байдлаар хүлээн авах болон Хог хаягдлын удирдлагын төв, хаягдал шатаах зуухны үйл ажиллагаатай холбоотой.
  - Хог хаягдлыг ажлын талбайгаас цуглуулж, тэдгээрийг Хог хаягдлын удирдлагын төв рүү шилжүүлэх.
- Ялангуяа холбогдох хог хаягдлыг цуглуулсан тоо мэдээ, дахин боловсруулах, Хог хаягдлын удирдлагын төв дээр хог хаягдал булах, шатаах зуух руу шилжүүлэхтэй холбоотойгоор Дэд бүтцийн хэлтэс болон Байгаль орчны хэлтэс.

## 4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 3.0

Төслийн бүхий л үйл ажиллагаанд хамаарах, хэрэгжүүлэх шаардлагатай стандартуудыг (төслийн стандартууд) дагаж мөрдөнө. Төслийн стандартуудад:

- Монгол улсын холбогдох хууль тогтоомж, үндэсний стандартууд;
- БОНБНУ-нд заасан шаардлагууд;
- Монгол улсын Засгийн газар, холбогдох агентлагуудаас тавьсан шаардлагууд;
- Зээлдүүлэгчдийн стандарт болон зааварчилгаанууд;
- Рио Тинтогийн стандартууд; ба
- Оюутолгойн зүгээс дагаж мөрдөх үүрэг бүхий бусад аж үйлдвэрийн салбарын зааварчилгаанууд ордог.

### 4.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж, үндэсний стандартууд

Аюултай материалтай харьцах талаарх Монгол улсын үндэсний стандартуудыг доор жагсаан орууллаа. Үүнд:

- 2006 оны Монгол улсын Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) аюултай бодистой хамааралтай зохицуулалтуудыг хийсэн байдаг. Түүнчлэн ус нь аюултай бодисоос үүдэх нөлөөллийг хүлээн авагч, өртөгч тул усны чанарын стандарт (MNS 4586:98) мөн хамааралтай;
- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам (Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд болон Гадаад харилцааны яамны сайдын хамтарсан 334/104 тоот тушаалын хавсралт);
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Эрүүл мэндийн яамны сайд болон Онцгойбайдлын ерөнхий газрын даргын хамтарсан 28/40/29 тоот тушаалын хавсралт 1, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Эрүүл мэндийн яамны сайд болон Онцгойбайдлын ерөнхий газрын даргын хамтарсан 28/40/29 тоот тушаалын хавсралт 2, Химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ хийх журам;
- Монгол улсын Засгийн газрын 264-р тогтоолын хавсралт, төрөл бүрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлын жагсаалт;
- МУ-ын Байгаль орчны яамны 2003 оны 127-р тушаалын хавсралт, Аюултай хог хаягдлыг хадгалах, зайлуулсан тухай бүртгэл хөтлөх зааварчилгаа
- Аюултай бодисуудыг Монгол улсын Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, үүнд заасан тайлагналтын шаардлагуудын (9.1 дүгээр заалт) дагуу ашиглана.

Хог хаягдлын талаарх Монгол улсын хууль тогтоомж, үндэсний стандартуудыг доор жагсаав:

- Өмнөх Хог хаягдлын тухай хуулийг орлох (2012), 2017 онд баталсан Хог хаягдлын тухай Монгол улсын хуульд хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, зайлуулах асуудлыг зохицуулсан. Хог хаягдлыг дараах байдлаар ангилсан: а) ахуйн хог хаягдал б) аюултай хог хаягдал (хүн, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд хортой). Аюултай хог хаягдлыг урьдчилан тогтоосон арга техник ба/буюу технологийн дагуу зориулалтын төвлөрсөн хог хаягдалын цэгт зайлуулах ёстой. Энэхүү хуулиар хог хаягдал дахин боловсруулах, дахин ашиглахыг хөхиүлэн дэмжсэн. Хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах зэрэг үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж нь эцсийн бүтээгдэхүүнийг өмчлөх эрхтэй байна. Аймаг, нийслэлийн засаг дарга нар тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын явуулж буй хог хаягдлын удирдлагын үйл ажиллагаанл ерөнхий хяналт тавина.

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 3.0

- 2006 онд батлагдсан Аюултай, хортой хог хаягдлыг тухай хуулиар (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) хортой химийн бодисыг импортлох, экспортлох, тээвэрлэх, хадгалах, ашиглах хянах асуудлыг зохицуулдаг. Энэхүү хуулинд хүний эрүүл мэнд, байгаль орчинд буй хортой, аюултай химийн бодисын үр нөлөөнөөс сэргийлэх арга хэмжээний талаар заасан байдаг.
- 1998 онд батлагдсан Эрүүл ахуйн тухай хууль (2016 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) нь хөрсний эрүүл ахуй, хог хаягдал зайлуулах, бохирын усны байгууламж, усны цооног, бие засах газар болон эмнэлгийн хаягдал, цацраг идэвхт, хортой химийн бодисын талаар иргэд, аж ахуйн нэгжүүдийн хүлээх үүрэг хариуцлагыг заасан байдаг.
- 2002 онд гарсан Засгийн газрын 135-р тогтоолд аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, баглаж боох, тээвэрлэх, цэвэрлэх, хадгалах, зайлуулах журмыг заасан байдаг.
- Байгаль, орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2011 онд гаргасан хамтарсан А-320/305-р тогтоолд эмнэлгийн хаягдлыг зайлуулах журмыг заасан байдаг.
- 2006 онд гаргасан Байгаль, орчин, аялал жуулчлалын сайдын 404-р тогтоолд иргэд, аж ахуйн нэгжийн хог хаягдал зайлуулах, булах болон хог хаягдлыг булах, зайлуулах үйл ажиллагааг зохицуулсан байдаг.

### 4.2 БОНБНУ-ны шаардлагууд

Төслийн хэд хэдэн БОНБНУ-нүүдийн хүрээнд боловсруулан гаргасан Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ), орчны мониторингийн төлөвлөгөө (ОМТ)-г хянан үзэж, холбогдох шаардлагуудыг дээрх Бүлэг 4.1, Хүснэгт 2- *Удирдлагын гол хяналт*, Хүснэгт 4- *Мониторингийн гол арга хэмжээ* хэмээх хэсгүүдэд нэгтгэн орууллаа. Аюултай материалд хамаарах гол БОНБНУ-нүүдийн нэг бол Оюутолгойд ашиглах химийн бодисын хэмжээ, төрөл болон тэдгээрийн үзүүлж болох сөрөг нөлөөллийг багтаасан, 2006 онд боловсруулсан Оюутолгойн зэс-алтын уурхай, баяжуулах үйлдвэрийн нэмэлт БОНБНУ болон БОНБНУ-д 2012 онд оруулсан нэмэлт өөрчлөлт юм.

### 4.3 МУ-ын Засгийн газрын агентлагуудаас тавьдаг бусад үүрэг даалгаврууд

Хөрөнгө оруулалтын гэрээний 6.4, 6.9 болон 6.10 дугаар заалтууд нь ерөнхийдөө Оюутолгой дахь аюултай материалуудын удирдлагатай холбоотой:

- Хөрөнгө оруулагч нь Оюутолгой төслийн хэрэгжилттэй холбоотой БОХТ, ОМХ-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах жил бүрийн бүх зардлыг хариуцах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд дурдсан арга хэмжээг хэрхэн биелүүлж байгаа тухай хараат бус, мэргэшсэн, эрх бүхий гадаадшинжээчийн тайланг 3 (гурван) жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- Хөрөнгө оруулагч нь гол үйл ажиллагаатайгаа холбоотой байгаль орчны шинжилгээ, мониторингийн цогц үнэлгээний хөтөлбөрийн тайланг жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- Байгаль орчны мониторингийн хөтөлбөрөөр агаар, ус, хөрс, амьтан, ургамал болон газрын хэвлийд аливаа бодит сөрөг нөлөөлөл үзүүлсэн нь тогтоогдвол хөрөнгө оруулагч уг нөлөөллийг арилгах шаардлагатай арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

Хөрөнгө оруулалтын гэрээнд аюултай материал болон эрдсийн бус хаягдлын удирдлагын талаар тусгайлсан заалт байхгүй.

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 3.0

### 4.4 Олон улсын болон Зээлдүүлэгчдийн стандарт болон удирдамжууд

Олон улсын бараа бүтээгдэхүүнийг хаях дараах зааварчилгаа, хууль тогтоомжийг ашигласан болно.

- Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны Гүйцэтгэлийн шаардлагууд (2008 он) (ялангуяа ГС 1: Нийгэм, байгаль орчны үнэлгээ болон удирдлагын системүүд, ба ГС 3:Бохирдлоос сэргийлэх болон бууруулах);
- Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-ын уул уурхайн Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа (БОЭМАА)-ны зааварчилгаанууд, 2007 он;
- ОУСК-ийн БОЭМАА-ны ерөнхий зааварчилгаа, 2007 он.
- Хог хаягдал хүлээн авах, булах зааварчилгаа (ИБУИНВУ-ын байгаль орчны агентлаг 2010)
- Аюултай хаягдал – Аюултай хаягдлын тодорхойлолт, ангилалын тухай тайлбар (2013 онд гарсан 3-р хувилбар) (Уэльсийн байгалийн нөөц баялгийн газар, 2013)
- ОУСК-ийн уул уурхайтай холбоотой БОЭМАА-ны зааварчилгаа, 2007;
- ОУСК-ийн БОЭМАА-ны ерөнхий зааварчилгаа, 2007;
- ОУСК-ийн гүйцэтгэлийн 3-р стандарт – Бохирдлоос сэргийлэх, бууруулах (2006);
- ЕСБХБ-ны гүйцэтгэлд тавигдах шаардлага (ялангуяа ГС1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ, удирдлага ГС3: Бохирдлоос сэргийлэх, бууруулах).

ЕХ болон олон улсын хог хаягдлын удирдлагын дараах стандартуудын шаардлагыг хангах байдлаар ОТ төслийн талбай дээр байрлах Хог хаягдлын удирдлагын байгууламжийг барьж, үйл ажиллагааг боловсруулсан:

- ЕХ-ны удирдамж 99/31/ЕХ, 1999 (хог хаягдлыг газарт булах);
- ДЭМБ-ын Эмнэлгийн хог хаягдлыг аюулгүй хаях удирдлага: Бодлогын баримт бичиг, баримт бичиг № 281 (эмнэлгийн хог хаягдлын удирдлага);
- Аюултай хог хаягдал, тэдгээрийг зайлуулахдаа хил дамнаж шилжүүлэхэд хяналт тавих тухай конвенци (Базелийн конвенци, Монгол улс 1997 онд нэгдэн орсон);
- АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн CFR 258 (хотын хатуу хог хаягдлыг булах шалгуур), газарт булах, шатаахтай холбоотой тусгай шаардлагыг доор үзүүлэв.

### 4.5 Рио Тинтогийн холбогдох стандартууд

Аюултай материалын удирдлагад хамаарах Рио Тинтогийн гол стандарт нь *Е5- Аюултай материалууд болон эрдсийн бус хаяглыг хязгаарлаж бууруулах, 2014 он* хэмээх стандарт юм.

Аюултай материалтай холбоотой Рио Тинтогийн бусад баримт бичгүүдэд:

- Н1 Химийн бодис болон аюултай материалын нөлөөг хянах стандарт (Хөдөлмөрийн эрүүл мэнд);
- Е12 Агаарын чанарыг хамгаалах стандарт;
- Е14 Газар хөндөхөд хяналт тавих, нөхөн сэргээх стандарт;ба
- Е11 Усны чанарыг хамгаалах, усны менежментийн стандарт орно.

### 4.6 Оюутолгойн дагаж мөрдөх үүрэг бүхий бусад аж үйлдвэрийн салбарын зааварчилгаанууд

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 3.0

Төлөвлөгөөнд тусгагдсан олон улсын хэмжээний аюултай материалын стандартуудад доорх стандартууд багтана. Үүнд:

- Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай конвенц (Базелын конвенц, Монгол улс 1997 онд соёрхон баталсан);
- Төсөл нь олон улсын тэргүүлэх туршлага болох ЕХ-ны REACH (ЕС 1907/2006) зэрэг журмын зарчмыг багтаасан олон улсын стандартуудыг дагаж мөрдөх үүрэг амлалт авсан. Учир нээдгээр стандартуудын дагуу аюултай бодис, материалыг ашиглахаас аль болохоор зайлсхийх, маш аюултай химийн бодисуудыг орлуулах бодис гарангууторлуулан ашиглаж байх гол зарчимтай бөгөөд үүнийг 2.2-р бүлэгт дурдсан Оюутолгойнхэд хэдэн удирдлагын төлөвлөгөөнүүдэд тусгаж өгсөн.

### 4.7 Төсөлд хэрэглэх аюултай материалын стандартуудын хураангуй

Оюутолгой нь үндэсний стандартууд, Зээлдүүлэгчдийн стандартууд болон Рио Тинтогийн стандартуудаас хамгийн чанга, хатуу нөхцөлтэйг нь сонгон авчтөслийн стандартууд болгон хэрэгжүүлэх болно. Мөн аюултай бодис хадгалах агуулахнь тухайн хадгалж буй материалын нийт эзэлхүүний 110%-тай тэнцэх эзэлхүүнтэй бахангалттай агааржуулалттай байна гэх зэрэг стандартуудыг боловсруулан гаргасан.

Төсөл нь аюултай материалаас байгаль орчинд учрах аюул, эрсдэл, тэдгээрийн шинж чанарыг үнэлэн улмаар аюултай материалыг тээвэрлэх, ашиглах, шилжүүлэх, хаях үед алдагдах болон асгарахаас мөн асгаралтаас үүдэлтэй бохирдлоосурьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Эдгээр үйл ажиллагааг доор дурдсан төрлийн бодиснуудыг үнэлэх, батлах асуудлыг агуулсан ChemAlert системийг ашиглан хэрэгжүүлнэ:

- Аюултай бараа бүтээгдэхүүн хэмээн ангилагдсан;
- Химийн аюултай бодис хэмээн ангилагдсан;эсвэл
- Зөв эсвэл буруу хэрэглэх үед тодорхой аюул, хөнөөл учруулж болох бодисууд.

Тус үйл явцад

## 5 НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ, УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь доор дурдсан журам, зааварчилгаа буюу өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа Оюу толгой төслийн аюултай материал, эрдсийн бус хаягдлын Удирдлагын үйл ажиллагаануудыг нарийвчлан тусгасан журмуудаар баяжиж байдаг. Үүнд:

- Аюултай материал болон түлшний Удирдлагатэй аолбоотой Аюултай Материалын Удирдлагын Журам (ОТ-10-E5-PRC-0001).
- Аюултай болон химийн бодисоос үүдэлтэй осол зөрчлийн тохиолдолтой холбоотой, Осол зөрчлийн удирдлагын Журам (ОТ-14-PRC-0009).
- Нүүрсуст нэгдлээр боирдсон хөрсний
- Тэсрэх дэлбэрэх бодистой харьцах болон хадгалах асуудалтай холбоотой, Тэсэлгээний стандарт ажлын Журам.
- Аюултай бодисын асгаралтаас сэргийлэх болон хянах асуудалтай холбоотой, Асгаралтын Журам (ОТ-10-E15-PRC-0002).
- ОТ-н ажлын талбай дээр хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх удирдлагын үйл ажиллагаатай холбоотой, Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх ерөнхий журам (ОТ-10-E15-PRC-0006-E),

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 3.0

- Хог хаягдлын удирдлагын төв дээр аюултай бус хатуу хог хаягдлыг зайлуулах, аюултай хог хаягдлыг шатаах, дахин боловсруулах үйл ажиллагаатай холбоотой, Хог хаягдлын удирдлагын төвийн үйл ажиллагааны журам (ОТ-10-E15-PRC-0005-E).

Шаардлагатай тохиолдолд дээрх стандарт, журмуудаас гадна энэхүү Удирдлагын төлөвлөгөөнд дэмжлэг үзүүлэх өөр журам, стандартыг боловсруулж болно.

Энэхүү удирдлагын төлөвлөгөөний гол зорилго нь Оюутолгой уурхай дээрх химийн аюултай бодисын тээвэрлэлт, аюултай бодистой харьцаж ажиллах, хадгалах үйл ажиллагааг аюулгүй арга барилаар явуулахад оршино. Энэхүү зорилгыг Монгол улсын болон олон улсын стандартуудын дагуу химийн аюултай бодистой холбоотойгоор эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн удирдлагын хяналтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар хангана. Химийн аюултай бодисыг Монгол улс болон олон улсын холбогдох хууль тогтоомж, стандартуудын дагуу хянаж зохицуулна.

Доорхи Хүснэгт 2 нь Оюутолгойн авч хэрэгжүүлэх удирдлагын гол хяналтын арга хэмжээг тусган харуулсан. Эдгээр хяналтын арга хэмжээ тусгай журам (жишээ нь материалын зөвшөөрөл) эсвэл стандартын шаардлага хангасан ажлын туршлагын (жишээ нь химийн аюултай бодисын хадгалалт) тусламжтайгаар хийгдэнэ.

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 3.0

### Хүснэгт 2: Удирдлагын гол хяналтын арга хэмжээ

дугаар	Хэрэгжилт/ Үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах тал	Баталгаажуулалт
HWM01	Бүх аюултай материалын сонголт	Бүх аюултай материалыг Химийн бодисын БОНБНУ-ний шаардлагууд болон Оюутолгойн зааварчилгаанд заасны дагуу үнэлнэ. Тухайн үнэлгээг зохих мэргэжил ур чадвар бүхий, туршлагатай мэргэжилтнээр хийлгэн, ЭМААБОАБОН-ийн хэлтсээр батлуулна.	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> <li>• Хангамжийн хэлтэс</li> <li>• Ашиглалтын Ил уурхай болон Далд уурхайн хэлтсүүд</li> <li>• үндсэн гүйцэтгэгчид</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Химийн болон аюултай бодисын бүртгэл, тайлан</li> <li>• Аюултай материалын Удирдлагын Журам</li> </ul>
HWM02	Аюултай бодисын хадгалалт	Материалын Хор Аюулын Лавлах Мэдээлэл (МХАЛМ) Монгол, Англи болон бусад шаардлагатай хэл дээр химийн бодис хадгалж буй бүх байрлалууд дээр бэлэн байршуулна. Эдгээр нь хадгалж буй байрлалууд болон ашиглалтын гол цэгүүдэд бэлэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> <li>• Үндсэн гүйцэтгэгчид</li> <li>• Дэд бүтцийн хэлтэс</li> <li>• Ил болон Далд уурхайн хэлтсүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Аюултай Материалын Удирдлагын Журмыг 4.4-р хэсэг</li> <li>• Дотоод аудитын хөтөлбөр болон бүртгэл тэмдэглэл</li> <li>• Агуулахын хэсгүүдэд МХАЛМ-ыг зөв байршуулсныг ажиглалтаар шалгаж баталгаажуулах</li> <li>• Ажлын байрны үзлэг шалгалт</li> </ul>
HWM03	Аюултай бодисын хадгалалт	Шингэн аюултай бодис(хаягдал тос гэх мэт)-ын хадгалалтыг тухайн бодисын хэмжээний 110%-тай тэнцэх хоёрдогч битүүмж бүхий саванд хадгална.	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> <li>• Ашиглалтын Ил болон Далд уурхайн хэлтсүүд</li> <li>• үндсэн гүйцэтгэгчид</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Агуулахын зураг төсөл</li> <li>• Дотоод аудитын хөтөлбөр</li> <li>• Ажиглалт шалгалт</li> <li>• Аюултай Материалын Удирдлагын Журмыг 4.4-р хэсэг</li> </ul>
HWM04	Аюултай бодисын хадгалалт	Хаягдал тосыг газарт булсан хадгалах саванд удаан хугацаагаар хадгалахгүй бөгөөд хадгалах савыг байнга суллан, цууралт, цоорхой буй эсэхийг магадлан шалгана. Энэхүү үзлэгээр илэрсэн зөрчил, үүссэн цууралт, нүхийг бөглөн засч, бүх засварынажлыг бүртгэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> <li>• Ашиглалтын Ил болон Далд уурхайн хэлтсүүд</li> <li>• үндсэн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дотоод аудитын хөтөлбөр</li> <li>• Ажиглалт шалгалт</li> <li>• Аюултай Материалын Удирдлагын Журмыг 4.4-р хэсэг</li> </ul>



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 3.0

дугаар	Хэрэгжилт/ Үйл ажиллааа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах тал	Баталгаажуулалт
			гүйцэтгэгчид	
HWM05	Аюултай бодисын хадгалалт	Химийн аюултай бодистой харьцдаг газруудад асгаралтыг нэн даруй цэвэрлэж, нөлөөлөлийг бууруулах үүднээс асгаралтаас сэргийлэх, хамгаалах багаж хэрэгсэл болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг бэлэн байлгана.	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> <li>• Ашиглалтын Ил болон Далд уурхайн хэлтсүүд</li> <li>• үндсэн гүйцэтгэгчид</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дотоод аудитын хөтөлбөр</li> <li>• Ажиглалт шалгалт</li> <li>• Аюултай Материалын Удирдлагын Журмыг 4.4-р хэсэг</li> </ul>
HWM06	Аюултай бодисын хадгалалт	Нүд угаах тосгуур, шүршүүр болон анхны тусламжийн цүнхээрэг шаардлагатай анхны тусламжийн багаж хэрэгслийг аюултай материал хадгалж буй газруудад байрлуулна.	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> <li>• Ил болон Далд уурхайн хэлтсүүд</li> <li>• үндсэн гүйцэтгэгчид</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дотоод аудитын хөтөлбөр</li> <li>• Аюултай Материалын Удирдлагын Журмыг 4.4-р хэсэг</li> </ul>
HWM07	Аюултай бодисын тээвэрлэлт	Химийн аюултай бодисыг тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй ба/буюу Оюутолгойн зөвшөөрөгдсөн оператор л тээвэрлэлт хийнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> <li>• үндсэн гүйцэтгэгчид</li> <li>• Дэд бүтцийн хэлтэс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дотоод аудитын хөтөлбөр</li> <li>• Ажиглалт шалгалт</li> <li>• Аюултай Материалын Удирдлагын Журмыг 4.3-р хэсэг</li> </ul>
HWM08		Энэхүү Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө болон холбогдох журмыг хэрэгжүүлэх үед Хог хаягдлын удирдлагын шатлалын зарчмыг дараах шат дарааллын хүрээнд авч үзнэ. а) хог хаягдал гаргахгүй байх, эх үүсвэр дээр нь багасгах; б) хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах. с) хог хаягдал хадгалах, боловсруулах ба/буюу зайлуулах	<ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагааны Ил болон Далд уурхайн хэлтсүүд</li> <li>• үндсэн гүйцэтгэгч</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ерөнхий журам</li> <li>• Ажлын байрны шалгалт</li> </ul>
HWM09		Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн журам, заавар, тодорхойлолт арга зүйд үндэслэж бүх хог хаягдлыг дараах шалгуурын дагуу ангилна. Үүнд: а) эрдсийн хог хаягдал; б) аюултай бус хог хаягдал (ахуйн болон идэвхгүй хог хаягдал зэрэг); с) аюултай хог хаягдал (эмнэлгийн хог хаягдал зэрэг);	<ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагааны Ил болон Далд уурхайн хэлтсүүд</li> <li>• үндсэн гүйцэтгэгч</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ерөнхий журам</li> <li>• Ажлын байрны шалгалт</li> </ul>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: OT-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 3.0

дугаар	Хэрэгжилт/ Үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах тал	Баталгаажуулалт
		d) бохир ус (Усны менежментийн төлөвлөгөөг үзнэ үү)		
HWM10		Хог хаягдлыг эх үүсвэр (үүсгүүр) дээр нь ангилж, аюулгүй хадгалж хяналт тавина. Улмаар боловсруулалт, тээвэрлэлт, зайлуулалтын арга хэмжээ авна.	<ul style="list-style-type: none"> <li>• үндсэн гүйцэтгэгч</li> <li>• Үйл ажиллагааны Ил болон Далд уурхайн хэлтсүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ерөнхий журам</li> <li>• Ажлын байрны шалгалт</li> </ul>
HWM11			<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улирлын болон жилийн байгаль орчны тайлан</li> </ul>
HWM11		Гүйцэтгэгчид болон барилга байгууламжид үнэлгээ (ЭМААБОАБОН-ийн стандарт, тоног төхөөрөмж, тээвэрлэлт) хийсний дараа, дахин боловсруулах хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий Гүйцэтгэгчийн ажиллуулж буй байгууламж руу шилжүүлж болно.	<p>ЭМААБОАБОН-ийн хэлтэс</p> <p>Эрдсийн бус хог хаягдлын хороо ЭМААБО-ны хэрэгжилт хариуцсан баг</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ерөнхий журам</li> <li>• Дахин боловсруулах байгууламж дээр хийсэн үнэлгээ</li> </ul>
HWM12		Төслийн шаардлагыг хангасан тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдал зайлуулах байгууламжийг Монгол улсад байгуулах хүртэл, хог хаягдал дахин боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий Гүйцэтгэгч дахин боловсруулахаас бусад тохиолдолд, хог хаягдлыг төслийн талбайгаас гадуур зайлуулах, боловсруулахаар гаргахыг хориглоно.	<ul style="list-style-type: none"> <li>• үндсэн гүйцэтгэгч</li> <li>• Үйл ажиллагааны хэлтсүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ерөнхий журам</li> <li>• Ажлын байрны шалгалт</li> </ul>
HWM13		Аюулгүй хог хаягдлыг зөвхөн Хог хаягдлын удирдлагын төв дээр зайлуулна. Ингэхдээ, АНУ-ын Байгаль хамгаалах агентлагийн хотын хатуу хог хаягдлыг булах шалгуур үзүүлэлт 258 болон дотоодын хууль, журмыг баримталж газарт булах инженерчилсэн, удирдах газраас баталсан аргаар гүйцэтгэнэ. Түр булах талбайд (барилга угсралтын үе шат) булсан бүх хог хаягдлыг байнгын ажиллагаатай инженерчилсэн булах газар болон талбайн гадна батлагдсан байгууламж (дахин боловсруулах байгууламж гэх мэт) руу шилжүүлнэ. Түр булах талбайд	<ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтцийн хэлтэс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын удирдлагын төвийн инженерийн зураг төсөл</li> <li>• Хог хаягдлын удирдлагын төвийн үйл ажиллагаа явуулах журам</li> </ul>



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 3.0

дугаар	Хэрэгжилт/ Үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах тал	Баталгаажуулалт
		булсан хог хаягдлын болзошгүй бохирдолд үнэлгээг хийж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой эрсдэл учруулах аливаа бохирдрлыг засч залруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.		
HWM14		°C – д ариутгана.	<ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтцийн хэлтэс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын удирдлагын төвийн үйл ажиллагаа явуулах журам</li> </ul>
HWM15		Инженерчилсэн, батлагдсан боловсруулах, зайлуулах арга байхгүй бол боловсруулах ба/буюу зайлуулах арга замыг тодорхойлтол бүх аюултай хог хаягдлыг төслийн талбай дээр зохих журмын дагуу хадгална.	<ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтцийн хэлтэс</li> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын удирдлагын төвийн үйл ажиллагаа явуулах журам</li> <li>• Аюултай материалын удирдлагын журам</li> </ul>
HWM16		Хуримтлагдсан хог хаягдлын (жилийн тоо хэмжээ, хуримтлагдсан нийт тоо хэмжээ) тооллогыг байршлаар нь, төслийн талбайгаас гадна дахин боловсруулах явуулсан хог хаягдалаар нь, аюултай хог хаягдлыг боловсруулах арга ашиглах хог хаягдалаар нь, аюулгүй хог хаягдлыг боловсруулах арга ашиглах хог хаягдалаар нь, дахин боловсруулах боломжгүй аюултай хог хаягдалаар нь гаргана.	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• байгаль орчны улирлын, жилийн тайлан</li> </ul>
HWM17		Хатуу хог хаягдал (аюулгүй болон аюултай хог хаягдал)-ыг ил задгай газар шатааж устгахыг хориглоно.	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБОАБОН-ийн хэлтэс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын удирдлагын төвийн үйл ажиллагаа явуулах журам</li> </ul>
HWM18		PRC-0002-Е Асгаралтын үед авах арга хэмжээний журмын дагуу асгаралтыг удирдан зохицуулна.	<ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтцийн хэлтэс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Асгаралтын үед авах арга хэмжээний журам</li> <li>• Аюултай материалын удирдлагын төлөвлөгөө</li> </ul>

Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: OT-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 2.0

## 6. ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ

### 6.1 Удирдлагын төлөвлөгөөний хяналт болон өөрчлөлт

Энэхүү удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутамд дахин хянана.

ОТ компанийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутаг хариуцсан ерөнхий менежер буюу энэ удирдлагын төлөвлөгөөг хариуцагч тус төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах эрхтэй

Үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулах шаардлагатай бол (ОТ ЭМААБОАБОН-ийн удирдлагын системд заасан өөрчлөлтийн удирдлагын журамд тодорхойлсноор) энэ удирдлагын төлөвлөгөөг "шаардлагын дагуу" шинэчилж болно.

## 7. Мониторинг

### 7.1 Мониторингийн шаардлагууд

Хуулийн шаардлага болон стандартуудад нийцэж байгаа байгаа эсэхийг үнэлдэг, Ашиглалтын үеийн турш хэрэгжүүлэх шаардлагатай Мониторингийн арга хэмжээнүүдийг (4-р хэсэг. Төслийн стандартыг харна уу) тухайн хэсэгт тодорхойлсон. Төслийн стандартыг зөрчсөн тохиолдлыг илрүүлсэн тохиолдолд тухайн зөрчлийг судалж, тохирох арга хэмжээг тодорхойлсон (14-р элемент. ОТ ЭМААБОАБОН МС-ийн үл нийцэх байдлын осол зөрчил, арга хэмжээний удирдлага хэсгийг харна уу).

### 7.2 Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд

Оюу толгой нь аюултай материал, эрдсийн бус хаягдлын удирдлагын гүйцэтгэлээ цаашид үнэлсээр байна. Мониторингийн заалтуудыгдоор 7.3 хэсэгт харуулав. Аюултай материал, эрдсийн бус хаягдлын удирдлагыг үнэлдэг Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд (ГГҮ)-ийг хүснэгт 3-т харуулав.

#### Хүснэгт3: Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд

ID	ГҮҮ	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
HWM-KPI01	Энэхүү удирдлагын төлөвлөгөөгөөр тодорхойлсон нөлөөлөл бууруулах хяналтыг зөрчсөн тохиолдлын нийт тоо.	Зорилт: Тэг Тайланд тусгасан нийт тохиолдлуудын тоог бууруулж, үйл ажиллагааг сайжруулах	Хүснэгт 2 дээр буй "баталгаажуулалт" хэмээх баганыг үзнэ үү
HWM-KPI02	Хүн буюу байгаль орчинд бодит хор хохирол үзүүлэхүйц хэмжээнд химийн аюултай бодис алдагдсан тохиолдлын тоо.	Зорилт: Тэг Тайланд тусгасан нийт тохиолдлуудын тоог бууруулж, үйл ажиллагааг сайжруулах	Аудит
HWM-KPI03	Хог хаягдалтай холбоотой, мэдээлсэн осол зөрчлийн тоо	Энэхүү төлөвлөгөөг зөрчсөн тохиолдолыг багасгаж, тасралтгүй сайжруулах	Жил бүр гардаг хог хаягдалтай холбоотой мэдээлсэн осол зөрчлийн тоо
HWM-KPI04	Үүсч Хаягдлын удирдлагын төв рүү тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ	Үүссэн хог хаягдлын нийт хэмжээг бууруулж, гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах	Нэг хүнд ногдох аюулгүй хог хаягдлын сар тутмын тоо хэмжээ
HWM-KPI05	Дахин боловсруулсан материалын хувь хэмжээ	Газарт булж хог хаягдал зайлуулахыг бууруулж, гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах	Дахин боловсруулж болох материалын дахин боловсруулалтын хувь (жишээ нь хуванцар)

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 2.0

ID	ГҮҮ	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
HWM-KPI06	Хог хаягдалтай холбоотой орон нутгийн иргэдээс гаргасан гомдол саналын тоо	Хог хаягдалтай холбоотой орон нутгийн иргэдээс гаргасан гомдол саналын тоог бууруулж, гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах. Зорилт = тэг	Хог хаягдалтай холбоотой орон нутгийн иргэдээс гаргасан, мэдээлсэн гомдол саналын тоо (санал гомдол барагдуулах удирдлагын системд бүртгэгдсэн)
HWM-KPI07	Төслийн талбайн гадна хөрс бохирдуулсныг тогтоосон тохиолдол	Хог хаягдлын удирдлагын төв, хог хаягдал түр булах талбайн газар доорх усны анхны нөхцөл байдлыг хадгалах  Зорилт=газар доорх усны үндсэн нөхцөл байдалд аливаа аюултай материал ороогүй байх, байгалийн олон янз байдлыг хадгалсан байх (жишээлбэл, Монгол улсын хууль журам, төслийн стандартад заасан шаардлагаас хэтрээгүй байх)	Усны хяналт-шинжилгээний төлөвлөгөөний дагуу хог хаягдлын удирдлагын төв дээрх хяналтын худгийн газар доорх усанд хяналт хийж, шинжилгээ явуулах.  Түүнчлэн, үндсэн нөхцөл байдалд ямар өөрчлөлт гарвал нэмэлт судалгаа шинжилгээ, аюултай нөхцөл байдлыг бууруулах арга хэмжээ авах талаар Усны хяналт шинжилгээний төлөвлөгөөнд дурдсан болно.
HWM-KPI08	Хог хаягдал түр булах талбай дахь Газар доорх усны түвшин	Хог хаягдал түр булах талбайг хаасны дараа газар доорх усны нөхцөл байдлыг анхны байдалд оруулан нөхөн сэргээнэ.  Зорилт = Тухайн бүс нутгийн газар доорх усны чанарын хяналт шинжилгээний тоо мэдээтэй холбогдуулан 3 болон түүнээс дээш хэмжилт хийсний дараа хяналтын худаг дээр тогтоосон усны чанарт ямарваа тогтвортой өөрчлөлт гараагүй байх (Усны хяналт шинжилгээний төлөвлөгөөний 6.3-аас дэлгэрэнгүй мэдээлэл авах)	Газар доорх усны хяналт шинжилгээ – 1-р багцын хэмжээг Усны хяналт шинжилгээний төлөвлөгөөнд заасны дагуу хог хаягдал түр булах талбайн урсгал доор байрлах усны хяналтын худагаас авна.  <i>Санамж:</i> Хяналтын худгийг өрөмдөж гаргаагүй байгаа болно (2015 оны 6-р сар). Тус худгийг 2015 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд өрөмдөнө. Газар доор ус байхгүйг батлах хүртэл зохих гүнд буюу 10 м-ийн гүн хүртэл тус худгийг өрөмдөнө.

### 7.3 Мониторингийн гол үйл ажиллагаанууд

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 2.0

Хуулийн эрхзүйн болон холбогдох бусад шаардлага мөн хүснэгт 4-т одорхойлогдсон Төслийн стандартуудад нийцэмжтэй эсэхийг магадлах зорилгоор мониторингийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг. Мониторингийн ажлын үр дүнд төслийн стандартын шаардлагад үл нийцэх зөрчил илэрсэн тохиолдолд, тухайн зөрчлийг магадлан шинжилж, засан залруулах арга хэмжээг тодорхойлно (дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНМТ)-ий OT-10-PLN-0003 хэсгээсүзнэ үү). Төсөл 4-р хэсэгт тоймлон харуулсан Төслийн Стандартад нийцэж байгаа эсэхийг нягтлахын тулд Аюултай материалын удирдлагын аудит/хяналт шалгалтын хөтөлбөрийг (Оюу толгой болон гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд зориулж) боловсруулж хэрэгжүүлдэг.

**Хүснэгт 4. Мониторингийн арга хэмжээ – Химийн аюултай бодисын удирдлага**

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 2.0

ID	Сэдэв	Үзүүлэлт	Аргачлалууд	Хугацаа	Байрлал	Тайлбар
HWMM 01	Химийн аюултай бодисын бүртгэл	Аюултай материалын тоо хэмжээ	Оюутолгой нь өөрийн худалдан авч, түгээж, хадгалж, ашиглаж буй бүх химийн аюултай бодисын бүртгэлийг хөтлөнө.	Сар тутам шинэчлэх	Хамаарахгүй	
HWMM 02	Химийн аюултай бодистой харьцаж ажиллах	Янз бүр	Оюутолгой нь химийн аюултай бодистой холбогдолтой доор дурдсан мэдээллийг цуглуулан бүртгэл хөтөлнө: <ul style="list-style-type: none"> <li>• агуулахад байгаа бодисын нэгдсэн бүртгэл;</li> <li>• долоо хоног тутмын хэрэглээний нэгдсэн дүн;</li> <li>• агуулах бүрийн долоо хоног тутмын нийт дүн;</li> <li>• хэмжээнээс хэтэрсэн дүүргэлтэнд өгөх дохиоллын туршилт;</li> <li>• даралтын туршилт (хэрэв шаардлагатай бол);</li> <li>• хадгалах сав, дамжуулах хоолой, түгээлтийн системийн хяналт, ашиглалтын хяналт;</li> <li>• системд гарч буй ямар нэгэн өөрчлөлт;</li> <li>• асгаралт, хорогдлын тайлан;</li> <li>• асгаралтын эсрэг авсан хариу арга хэмжээний тайлан.</li> </ul>	Улирал тутам/өөр өөр	Хамаарахгүй	
HWMM 03	Хог хаягдалын бүртгэл/тооллого	Жил тутам үүсэх хог хаягдлын тоо хэмжээ, төрөл (нийт тоо хэмжээг орно)	Үүссэн хог хаягдал, төслийн талбайгаас гадна боловсруулахаар тээвэрлэсэн хог хаягдал, аюултай хог хаягдлын боловсруулалт хийх хог хаягдал, аюулгүй хог хаягдлын боловсруулалт хийх хог хаягдал, дахин боловсруулалт хийх боломжгүй аюултай хог хаягдлыг хадгалах агуулах.	Улирал тутам	Тодорхойгүй	ОТ-н Байгаль орчны хэлтэс
HWMM 04	Ажлын байрны үзлэг шалгалт	Тодорхойгүй	Талбайн ЭМААБОАБОН-ийн Ахлах мэргэжилтэн/Ахлах ажилтан ажлын байрны эмх цэгцийн ерөнхий үзлэгийг хийнэ.	Тогтмол	Бүх ажлын байран дээр	
HWMM 05	салбарын	Тодорхойгүй	Ямарваа осол зөрчил гарвал Осол зөрчлийн удирдлагын системд мэдээлнэ.	Сар тутам	Бүх ажлын байран дээр	
HWMM 05	Гуравдагч этгээдийн баталгаажуулалт, үнэлгээ	Тодорхойгүй	ОТ нь аливаа гуравдагч этгээд болох Гүйцэтгэгч, дахин боловсруулахаар төслийн талбайн гадагш явуулсан хог хаягдалд ашиглах байгууламжид тогтмол хяналт шалгалт хийнэ. Гүйцэтгэгчийн оролцоог хангах үйл явцад хяналт шалгалт хийх давтамжийг тухай бүрт нь тодорхойлно.	Гэрээ байгуулсан үед болон түүнээс хойш тогтмол	3-дагч этгээдийн хог хаягдлын гүйцэтгэгчийн байгууламж	
HWMM	Байгаль орчны	Метан	ОТ нь Хог хаягдлын удирдлагын төв, хаагдсан хог	Жил бүр	Хог хаягдлын	Усны хяналтын

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 2.0

06	хяналт шинжилгээ		хаягдал түр булах талбай дахь метаны түвшинг хянаана.		удирдлагын төвийн хог хаягдал түр булах талбай	төлөвлөгөөний хүрээнд
HWMM 07	Байгаль орчны хяналт шинжилгээ	Газар доорх ус	ОТ нь Хог хаягдалын удирдлагын төв, хог хаягдал түр булах талбай дахь газар доорх усанд хяналт шинжилгээ хийнэ	Жил бүр	Хог хаягдлын удирдлагын төвийн завсрын үе шатны хог хаягдал булах талбай	Усны хяналтын төлөвлөгөөний хүрээнд
HWMM 09	Байгаль орчны хяналт шинжилгээ	Аюултай хаягдал шатаах зуух	ОТ нь аюултай хаягдал шатаах зуухнаас гарах хорт хий	Шатаах зуух ажиллах хугацаанд байнга	Аюултай хаягдал шатаах зуух	Агаар дахь хорт хийн хяналтын төлөвлөгөөний

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е15-PLN-0001-М	Хувилбар: 2.0

## 8. СУРГАЛТ

### 8.1 Тойм

Шаардлагатай бүх сургалтыг чиг баримжаа олгох сургалт, зааварчилгаа (ерөнхий ойлголт, чиг баримжаа олгох) болон ажлын байран дээрхи сургалтын нэг хэсэг болгон заавал явуулна.

### 8.2 Чиг баримжаа олгох сургалт, зааварчилгаа

Оюутолгойн бүх үндсэн болоод гэрээт ажилтнууд нь ерөнхий чиг баримжаа олгох зааварчилгаа, уурхайн цогцолборын тусгайлсан зааварчилгаа болон ЭМААБОАБОН-ийн мэдлэг олгох сургалтад зайлшгүй хамрагддаг. Асгаралт болон бусад онцгой байдлын үед баримтлах журам, сургалтын талаар Оюутолгойн Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан (лаэ: ОТ-12-PLN—0011-Е).

Химийн аюултай бодис, эрдсийн бус хаягдалтай харьцан ажиллаж буй ажилчдыгшаардлагатай бүх хувийн хамгаалах хэрэгслээр хангана. Түүнчлэн бүх ажилчдыгхамгаалах хэрэгслийнзөв хэрэглээ болон арчлалт хамгаалалтын талаарх сургалтанд хамруулна.

### 8.3 Ажлын байран дахь сургалт

Оюутолгойд химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдалтай харьцан ажиллаж байгаа бүх ажилчдад ээлж бүрийн өмнө ажлын болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгнө. Энэхүү сургалтаар аюултай бодис, эрдсийн бус хог хаягдал, тухайлбал тэсрэх бодисыг аюулгүй хадгалж, түүнтэй зөв харьцах, хог хаягдал ангилах, ялгах талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

Хог хаягдал болон химийн аюултай бодис тээвэрлэгч гэрээт гүйцэтгэгч нь зохих сургалтад хамрагдсан байх шаардлагатай бөгөөд тээвэрлэлтийн явцад химийн аюултай бодисын санамсаргүй алдагдалгүй байхаар зөв, аюулгүй тээвэрлэнэ.

### 8.4 Сургалтанд тавигдах бусад шаардлагууд

Химийн аюултайбодис, эрдсийн бус хог хаягдлыг ашиглах, хадгалах болон харьцах ажилд оролцожбуй бүх ажилтнуудыгмэргэжлийн тусгай сургалтанд хамруулна.

Хог хаягдал булаах, шатаах зуухны ажилтнуудад ямар хог хаягдлыг дахин боловсруулж, дахин ашиглаж, эсвэл газарт булж, шатааж болох талаар дэлгэрэнгүй ойлголт өгөхийн тулд хог хаягдал ангилах сургалтад хамруулна. Шаардлагатай тохиолдолд онцгой байдлын үед авахарга хэмжээний төлөвлөгөөнд багтсанзарим шаардлагатай ур чадварыг эзэмшсэн байх ёстой.

**ОЮУ ТОЛГОЙ ХХК**

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 2.0

**9. АУДИТ БОЛОН ТАЙЛАГНАЛТ****9.1 Дотоод аудит**

Тогтмол үзлэг шалгалтыг тухайн ажлын талбайн болон ЭМААБОАБОН-ийн асуудал хариуцсан ажилтнууд ЭМААБО-ны талаас хийж гүйцэтгэнэ.

Үзлэг шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийг Осол зөрчлийн удирдлагын системд тайлагнаж бүртгэнэ (14-р элемент).

Хуулийн шаардлагад нийцэмжтэй байдал нь Гүйцэтгэлийн үнэлгээ ба аудитын 16-р элементийн дагуу жилийн дотоод аудитаар хянан шинжлэгддэг. Энэ нь ЭМААБОАБОН-ийн удирдлагын системийн (БОННБҮ болон удирдлагын төлөвлөгөө орно) шаардлагад нийцэмжтэй байдлыг үнэлэхийн тулд гүйцэтгэгддэг.

Энэхүү мониторингоор илэрсэн бүх осол зөрчил болон үл нийцэл нь БОННБҮ-нд тусгагдсантай адил Оюу толгойн ЭМААБО-ны Удирдлагын системийн шаардлагын дагуу бүртгэгдэн тайлагнаж байна.

**9.2 Гадаад аудит**

Энэхүү төлөвлөгөөнд нийцэмжтэй байдал нь Рио Тинто корпорацийн ЭМААБО-ны Бизнесийн нийцлийн аудитийн хөтөлбөр болон Зээлэгчдийн аудитаар тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлэгдэж байна.

**9.3 Баримтын хадгалалт**

Аудит, хяналт шалгалт болон осол зөрчил нь Баримт бичгийн хяналт (ОТ-08-PRC-0001) хэмээх 8-р элемент болон Мэдээлэл, түүнийг бүртгэлийн Удирдлага хэмээх 15-р элементийн (ОТ-15-PRC-0001) дагуу зохицуулагдана.

Рио Тинтогийн Бизнес шийдэл программ нь Дотоод, гадаар аудитуудаар илэрсэн зөрчил болон тохирох арилгах арга хэмжээнүүд, Осол зөрчил болон холбогдох шинжилгээ, арилгах бууруулах арга хэмжээнүүдийг бүртгэлжүүлэхэд хэрэглэгдэнэ.

**10. БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ**



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 2.0

Файлын нэр	ОТ-10-E15-PLN-0001-M- Химийн Аюултай бодис болон эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө
Тодорхойлолт	Химийн Аюултай бодис болон эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө
Эхийг зохиогч	Байгаль орчны хэлтэс, Химийн бодис ба Хог хаягдлын удирдлагын баг
Үүсгэсэн огноо	2013.09.01
Баталсан албан тушаалтан	Керри Эдвардс, ЭМААБОАБОН-ийн хэлтэсийн Ерөнхий менежер
Баталсан огноо	2013.09.01
Өөрчлөлтийг бүртгэх дугаар	#2

Эрсдлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Үнэлгээ хийсэн албан тушаалтан	Хянах хугацаа	Дараагийн хянах огноо
Дунд	2013.09.01	Химийн бодис, хог хаягдлын удирдлагын баг	2 жил бүр	2020.07.19

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварласан тэмдэглэл
1.0	2013.09.01	Химийн бодис, хог хаягдлын удирдлагын баг	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер	Баталсан.
1.1	2013.11.23	Л.Мөнхцацрал	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер	Баримт бичгийн дугаарыг засч, баримт бичгийг хянав.
2.0	2015.05.31	Н. Эрдэнэбаяр Махони Д'Алтерио Деннис Хосак	Керри Эдвардс, ЭМААБОАБОН-ийн хэлтэсийн Ерөнхий менежер	Тогтмол хяналт, өөрчлөлт оруулсан тухай тэмдэглэл 2015-7 Рио Тинтогийн E15 стандартын өөрчлөлтийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулав.  Эрдсийн бус хог хаягдал, аюултай материалын удирдлагын YAMT-г нэгтгэв.
3.0	2018.07.19	Б.Ууганбаяр Н.Эрдэнэбаяр	Муррэй Свирипа, ЭМААБОАБОН	Тогтмол өөрчлөлт хяналт оруулсан тухай тэмдэглэл NOC 2019-

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

Химийн аюултай бодис, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E15-PLN-0001-M	Хувилбар: 2.0

			– ийн хэлтсийн Ерөнхий менежер	007 - Албан тушаал, Үүрэг хариуцлагын хэсгийг шинэчлэн найруулав. -Төслийн стандартын хэсгийг шинэчлэн найруулав. -Шатаах зуух болон үржил шимт хөрсний цэвэрлэгээний үйл ажиллагааны журмын тухай хэсгийг хасаж, автоклаваар ариутгах гэсэн хэсгийг нэмж оруулав. Хуул эрхзүйн баримт бичиг хэсгийг шинэчлэв.
--	--	--	--------------------------------------	--